

# КОВИД-19 Сургуулийн гарын авлагын хураангуй

Бэлтгэл ангиас 12-р ангитай улсын, хувийн болон  
улсын санхүүжилттэй сургуулиуд

---



CORONAVIRUS  
UTAH.GOV

# Хэрэв сурагчид, багш нар эсвэл ажилчдын КОВИД-19 вирусын шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд юу болох вэ?



Сурагчид, багш нар эсвэл ажилчдын КОВИД-19 вирусын шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд шууд тусгаарлах хэрэгтэй. Энэ нь эмнэлгийн тусламж авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байх хэрэгтэй гэсэн үг юм. Та сургууль эсвэл ажилдаа явах ёсгүй.

Хэрэв таны шинжилгээний хариу эерэг гарсан бол та дараах нөхцөлийг хангатад өөрийгөө тусгаарлах хэрэгтэй:

- 24 цагийн турш халуураагүй, ба
- Таны амьсгалын замын шинж тэмдэг 24 цагийн турш сайжирсан, болон
- Анх өвчилснөөс хойш дор хаяж 10 хоног болсон.
- Хэрэв танд шинж тэмдэг илрээгүй бол та шинжилгээнд хамрагдсан өдрөөс хойш 10 хоног өөрийгөө тусгаарлах хэрэгтэй.

## Сурагчид, багш нар эсвэл ажилчид КОВИД-19 туссан хүнтэй хавьтсан тохиолдолд юу болох вэ?

Хэрэв та КОВИД-19 вирусын шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй ойр харилцсан бол халдвар авах болон бусдад халдаах эрсдэл өндөр байдаг.

Ойр харилцах<sup>1</sup> гэдэг нь та 24 цагийн дотор КОВИД-19 вирусын шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй 6 фийт буюу 2 метр хүрэхгүй (ойролцоогоор 2 дэлэм) зайтай нийт 15 минут эсвэл түүнээс дээш хугацаагаар ойр байсныг хэлнэ.<sup>2</sup> Мөн дараах тохиолдолд та ойрын хавьталд орсон байж болно:

- Та гэртээ КОВИД-19-өөр өвчилсөн хүнийг асран халамжилж байсан.
- Та КОВИД-19-тэй хүнтэй шууд харьцсан (тэднийг тэвэрсэн эсвэл үнссэн гэх мэт).
- Та КОВИД-19 туссан хүнтэй хоол ундны хэрэгслийг хамт хэрэглэсэн.
- КОВИД-19-тэй хүн найтаах, ханиалгахад, эсвэл амьсгалын замаар дамжин шүлсний дусал танд үсэрсэн байх.



Хэрэв та шинж тэмдэг илрэхээс нь өмнө КОВИД-19 туссан хүнтэй 2 хүртэлх хоног ойр харьцсан бол вирусээр халдварлах эрсдэлтэй байсан тул хөл хорионд орох хэрэгтэй. КОВИД-19 вирустэй хүнд ямар ч шинж тэмдэг илрээгүй байсан ч тухайн хүн шинжилгээ өгөхөөс өмнө 2 хүртэлх хоног халдвар тараах боломжтой.

<sup>1</sup> <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/if-you-are-sick/quarantine.html>

<sup>2</sup> <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/php/contact-tracing/contact-tracing-plan/appendix.html#contact>

# Сурагчид, багш нар эсвэл ажилчид хэр удаан хөл хорионд байх хэрэгтэй вэ?

Эдгээр удирдамж нь зөвхөн сургуульд тохиолддог өртөлтөд хамаарна. Тэдгээрийг дээд боловсролын байгууллага эсвэл хүүхэд асрах газар дагаж мөрдөх зориулалтгүй юм. Хэрэв та КОВИД-19 вирусгүй хүнтэй хамт амьдардаг эсвэл сургуулиас гадуур хавьталд өртсөн бол тус удирдамж ҮЙЛЧЛЭХГҮЙ.



## Хэрэв хавьталд өртөх үед тухайн хоёр хүн хоёулаа амны хаалт зүүсэн байсан бол

КОВИД-19 туссан хэн нэгэнтэй хавьталд орсон сурагчид, багш нар эсвэл ажилчид дараах тохиолдолд хөл хорионд орох шаардлагагүй:

- Сургуулиас мужийн нийгмийн эрүүл мэндийн газрын захирамжид заасны дагуу амны хаалтыг тухайн хоёр хүн (хавьталд орсон хүн болон шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн) хоёулаа зүүсэн болон
- Хавьталд өртсөн хүнд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илрээгүй эсэхийг баталгаажуулж болно.

Хэрэв хавьталд өртсөний дараа 14 хоногийн хугацаанд тухайн хүнд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илэрвэл тухайн хүнийг тэр даруй тусгаарлаж, шинжилгээ авах хэрэгтэй. Хэрэв тухайн хүнд шинж тэмдэг илрээгүй бол шинжилгээ өгөхийн тулд хавьталд өртсөнөөс хойш 7 хоног хүлээх хэрэгтэй.

## Хэрэв хавьталд орох үед хоёр хүний аль нь ч амны хаалт ЗҮҮГЭЭГҮЙ байсан бол

Хавьталд орох үедээ амны хаалт зүүгээгүй эсвэл амны хаалт зүүгээгүй хэн нэгэнтэй хавьталд орсон сурагчид, багш нар эсвэл ажилчид дараах тохиолдолд хөл хориогоо зогсоож болно:

- **10 дахь өдөр шинжилгээ өгөхгүйгээр.** Хэрэв танд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илрээгүй бол та шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хамгийн сүүлд ойрын хавьталд орсоноос хойш 10 хоногийн дараа хөл хориогоо зогсоож болно.
- **Шинжилгээний хариу сөрөг гарсан бол 7 дахь өдөр.** Та хөл хорионы 7 дахь өдөр шинжилгээнд хамрагдаж болно. Хэрэв таны шинжилгээний хариу сөрөг гарсан бөгөөд танд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илрээгүй бол хөл хориогоо зогсоож болно. Та шинжилгээ өгөхийн тулд хавьталд орсон дараа дор хаяж 7 хоног хүлээх ёстой. Шинжилгээ нь PCR эсвэл эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ байж болно. Шинжилгээний хариу гартал та хөл хориогоо үргэлжлүүлэх ёстой.



## Та вирусийн хавьталд өртсөнөөс хойш 14 хоног өнгөртөл өвчний шинж тэмдэг илрэх эсэхийг ажиглах хэрэгтэй.

Танд КОВИД-19 вирус халдвар авах магадлал бага хэмжээтэй байсаар байна. Хэрэв танд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илэрвэл гэртээ өөрийгөө тусгаарлаж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч рүүгээ ярих хэрэгтэй бөгөөд дахин шинжилгээ өгөх шаардлагатай болж магадгүй.



## Хэрэв сурагчид, багш нар эсвэл ажилчид амны хаалт зүүхээс чөлөөлөгдсөн эсвэл зөвхөн нүүрний хамгаалалт зүүж байсан бол тэд хөл хорионд хэр удаан байх ёстой вэ?

Хавьталд орох үедээ амны хаалт зүүгээгүй эсвэл амны хаалт зүүгээгүй хэн нэгэнтэй хавьталд орсон сурагчид, багш нар эсвэл ажилчид дараах тохиолдолд хөл хориогоо зогсоож болно:

- **10 дахь өдөр шинжилгээ өгөхгүйгээр.** Хэрэв танд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илрээгүй бол та шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хамгийн сүүлд ойрын хавьталд орсоноос хойш 10 хоногийн дараа хөл хориогоо зогсоож болно.
- **Шинжилгээний хариу сөрөг гарсан бол 7 дахь өдөр.** Та хөл хорионы 7 дахь өдөр шинжилгээнд хамрагдаж болно. Хэрэв таны шинжилгээний хариу сөрөг гарч, танд КОВИД-19 өвчний ямар ч шинж тэмдэг илрээгүй бол хөл хориогоо зогсоож болно. Та шинжилгээ өгөхийн тулд хавьталд орсоны дараа дор хаяж 7 хоног хүлээх ёстой. Шинжилгээний хариу гартал та хөл хориогоо үргэлжлүүлэх ёстой.

**Хавьталд өртсөн хэн ч байсан хавьтлаас хойш 14 хоног өнгөртөл шинж тэмдэг илрэх эсэхийг ажиглах нь зүйтэй.** Тухайн хүнд КОВИД-19 вирусын халдвар авах магадлал бага хэмжээтэй байсаар байна. Хэрэв тухайн хүнд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илэрвэл гэртээ өөрийгөө тусгаарлаж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч рүүгээ ярих хэрэгтэй бөгөөд дахин шинжилгээ өгөх шаардлагатай болж магадгүй.



## Хэрэв сурагчид, багш нар эсвэл ажилчид КОВИД-19 вирусын халдвар авсан хүнтэй хамт амьдардаг бол тэд хөл хорионд хэр удаан байх ёстой вэ?

Хэрэв тантай хамт амьдардаг хүний КОВИД-19 вирусын шинжилгээний хариу эерэг гарсан бол үүнийг өрхийн хавьтагч гэж нэрлэдэг. Өрхийн хавьтагчдын вирусийн халдвар авах эрсдэл хавьгүй илүү өндөр байдаг.

Өрхийн хавьтагч болсон сурагчид, багш нар эсвэл ажилчид шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хавьталд орсон сүүлийн өдрөөс эхлэн 10 хоногийн турш хөл хорионд байх хэрэгтэй. **Хэдийгээр танд ямар нэг шинж тэмдэг байхгүй эсвэл шинжилгээний хариу тань сөрөг гарсан байсан ч та 10-хоногийн хөл хориогоо бүхэлд нь дуусгах ёстой.** Та 10 хоногоос өмнө хөл хориогоо зогсоож болохгүй.

Хамт нэг гэрт амьдардаг хүмүүсээсээ өөрийгөө тусгаарлах нь маш хэцүү байж болно. Хэрэв та КОВИД-19 вирусын шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хамт амьдардаг бол та байнга хавьталд орсоор байна гэсэн үг тул 10-аас олон хоног хөл хорионд байх шаардлагатай байж магадгүй юм. Халдвартай үедээ шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй ойр харьцах бүрдээ та вирусээр халдварлах эрсдэлтэй тул таны хөл хорио дахин эхэлнэ.

# Хэрэв сурагчид, багш нар эсвэл ажилчид КОВИД-19 вируст нэг бус удаа өртсөн ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?<sup>3</sup>

Хэрэв та КОВИД-19 вирусын шинжилгээний хариу тань эерэг гарснаас **90 хоногийн дотор** дахин КОВИД-19 вируст өртсөн (шинэ өртөлт) бөгөөд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илрээгүй бол энэ 90 хоногийн хугацаанд хөл хорионд орох эсвэл дахин шинжилгээнд хамрагдах шаардлагагүй.

**Та эдгээр удирдамжийг хамгийн сүүлд хавьталд өртсөн өдрөөсөө эхлэн 14 хоног дагаж мөрдөх хэрэгтэй.**

- Сургууль эсвэл ажилдаа явахын өмнө биеийн халуунаа хэмжих.
- Өдөр бүр КОВИД-19-ийн шинж тэмдгийг шалгах.
- Сургууль, ажил дээрээ эсвэл хамт амьдардаггүй хүмүүсийн ойр хавьд байхдаа амны хаалт зүүх.
- Хэрэв та өвдвөл эсвэл танд КОВИД-19 өвчний шинж тэмдэг илэрвэл шинж тэмдэг илэрч эхэлснээс хойш доод тал нь 10 хоног өөрийгөө тусгаарлаж, дахин КОВИД-19 вирусын шинжилгээнд хамрагдах шаардлагатай эсэхийг эмч эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч рүү залгаж асууна уу.

Хэрэв та КОВИД-19 вируст дахин өртсөн (шинэ өртөлт) бөгөөд таны КОВИД-19 вирусын шинжилгээний хариу эерэг гарснаас хойш **90-ээс олон хоног** өнгөрсөн бол та хөл хорионд орж, дахин шинжилгээ өгөх хэрэгтэй. Та хөл хорионд байх хугацаандаа өвдвөл эсвэл өвчний шинж тэмдэг илэрвэл өөрийгөө тусгаарлаж, эмч эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч рүү залгана уу. Гэсэн хэдий ч та 2-р хуудсан дээрх хөл хориог зогсоох шалгуурыг хангаж магадгүй.



<sup>3</sup> <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/php/contact-tracing/contact-tracing-plan/contact-tracing.html>

# КОВИД-19 вирусээр өвчилсөн хэн нэгэнтэй хавьталд орсон сурагчид, багш нар, ажилчдад зориулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд

- Өдөр бүр КОВИД-19-ийн шинж тэмдгийг шалгаж, боломжтой бол биеийн халуунаа хэмжээрэй. Хэрэв танд термометр байхгүй бол арьсаа дулаацуулж эсвэл улаавтар харагдаж байгаа эсэхийг шалгаарай. "Хэрэв та хөл хорионд орсон эсвэл өөрийгөө тусгаарласан бол юу хийх хэрэгтэй вэ" гэсэн гарчиг бүхий хэрэгтэй товхимлыг <https://coronavirus.utah.gov/protect-yourself/> хаягаас татаж авч болно.
- Бусдаас аль болох хол, гэртээ бай. Таны хөл хорио дуустал эсвэл та хөл хориог эрт дуусгах шинжилгээний шаардлагыг хангатлаа сургууль, ажилдаа явж болохгүй бөгөөд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, шашны ёслол, гэр бүлийн цугларалт эсвэл бусад арга хэмжээнд оролцож болохгүй.
- Хэрэв та хүнсний бүтээгдэхүүн авах эсвэл эмнэлгийн тусламж авах зэрэг зайлшгүй шаардлагаар гэрээсээ гарах хэрэгтэй бол амны хаалт зүүгээрэй. Шаардлагатай бол л гэрээсээ гараарай.
- Гэртээ ирэх зочдын тоог хязгаарлах. Хэрэв та эсвэл тантай хамт амьдардаг хүн КОВИД-19-ээс хүнд өвчин тусах эрсдэл өндөр байвал энэ нь ялангуяа чухал юм.
- Гараараа байнга хүрдэг гадаргууг цэвэрлэх (утас, хаалганы бариул, гэрлийн унтраалга, суултуурын татуурга, угаагуурын холигч, тавцан, аливаа металл эд зүйлс).
- Гараа савантай усаар ойр ойрхон угаах Хэрэв саван, ус байхгүй бол дор хаяж 60%-ийн спирт агуулсан гар ариутгагч бодис хэрэглэнэ.
- Өрөөнүүдийн агааржуулалтыг сайжруулах, агаарын солилцоог нэмэгдүүлэхийн тулд цонхоо аль болох нээ.
- Хоол, ундны хэрэгслийг бусадтай хуваалцаж болохгүй.
- Сойз зэрэг хувийн эд зүйлээ бусадтай хуваалцаж болохгүй.



# Сургуульд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ (сургууль дээрх өвчний дэгдэлттэй холбоотой шинжилгээ)

Аливаа сургууль нь КОВИД-19 халдвартай холбоотой Сургуулийн Гарын Авлагад заасан халдварын дэгдэлтийн босгыг хангаж байгаа тохиолдолд орон нутгийн сургуулийн удирдах зөвлөл (орон нутгийн эрүүл мэндийн газартай зөвшилцөн) дараах шийдвэрийг гаргаж болно:

- Бүх сурагчид болон ажилчдыг дор хаяж 10 хоногийн турш виртуал эсвэл зайны сургалтад шилжүүлэх, эсвэл
- Бүх сурагчид болон ажилчдад эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ санал болгох




## Эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ санал болгосон сурагчид:


- Хэрэв шинжилгээний хариу нь эерэг гарвал гэртээ өөрийгөө тусгаарлах ёстой.
- Хэрэв шинжилгээний хариу нь сөрөг гарвал биеэр ирж үргэлжлүүлэн суралцаж болно.
- Шинжилгээ өгөхгүй байхаар шийдсэн хүмүүс дор хаяж 10 хоногийн турш виртуал эсвэл зайны сургалтад шилжих хэрэгтэй.



ЭСВЭЛ



ЭСВЭЛ



Багш нар болон ажилчид шинжилгээ өгөхгүй байхаар шийдсэн эсвэл шинжилгээний хариу нь сөрөг хариу гарсан тохиолдолд ажил үүргээ биечлэн хэвийн үргэлжлүүлнэ. Хэрэв шинжилгээний хариу нь эерэг гарсан тохиолдолд гэртээ өөрийгөө тусгаарлах хэрэгтэй бөгөөд хэрэв КОВИД-19 вируст өртсөн бол хөл хорионы дэглэмийг дагаж мөрдөх шаардлагатай.

## Шинжилгээний хариу нь эерэг гарсан аливаа хүний хавьтлыг тогтооно.

Шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хавьталд орсон сурагчид, багш нар эсвэл ажилчид хөл хорионы дэглэмийг мөрдөх хэрэгтэй (2-р хуудсанд бий).

- Хэрэв та болон шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн хоёулаа сургууль дээр байсан бөгөөд хавьталд орох үедээ хоёулаа амны хаалт зүүсэн байсан бол та хөл хорионд орох шаардлагагүй. Хэрэв хоёр хүн хоёулаа амны хаалт зүүсэн ч байсан шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн дор хаяж 10 хоног өөрийгөө тусгаарлах хэрэгтэй.
- Хэрэв та сургууль дээр хавьталд өртсөн бөгөөд та эсвэл шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн амны хаалт зүүгээгүй байсан бол та хөл хорионд орох шаардлагатай. Та шинжилгээ өгөхгүйгээр 10 дахь өдөр эсвэл шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд 7 дахь өдөр хөл хориог зогсоож болно. Танд 10 дахь өдрөөс өмнө сургуульдаа эргэж ирэхээсээ өмнө 2 дахь шинжилгээ өгөх шаардлага гарах нөхцөл байдал үүсэж магадгүй.

“Сургуульд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ” сонголтын дагуу шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнийг тусгаарлаж эхлэх хугацааг янз бүрээр заасан заадаг. Хэрэв “Сургуульд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ” протоколын хүрээнд таны шинжилгээний хариу эерэг гарвал та шинж тэмдэг илэрч эхлэхэд бус харин шинжилгээ авсан өдрөөс эхлэн тусгаарлагдана. Танд шинж тэмдэг илрээгүй байсан ч гэсэн өөрийгөө тусгаарлах ёстой. Таны шинжилгээ өгөх өдрөөс өмнө 2 хүртэл хоног тантай ойр хавьталд байсан аливаа хүн хөл хорионд орох хэрэгтэй. **“Сургуульд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ” сонголтын хувьд үүнийг хамгийн сүүлийн хавьталд өртсөн өдөр гэж тооцдог.**

# Дугуйланд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ (ахлах сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагаатай холбоотой шинжилгээ)

Сурагчид, багш нар болон ажилчид дараах тохиолдолд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцож болно:


- КОВИД-19 вирусн шинжилгээг дор хаяж 14 хоногт нэг удаа өгөх. Шинжилгээ нь PCR эсвэл эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ байж болно.
- Тусгаарлагдаагүй эсвэл хөл хорионд ороогүй байгаа.
- КОВИД-19 өвчний ямар нэг шинж тэмдэг байхгүй.



Биеийн хүч тамир шаарддаг тэмцээн уралдаанд оролцоогүй эсвэл амны хаалт зүүх нь аюултай (усан бассейнд сэлэх гэх мэт) байхаас бусад тохиолдолд та хичээлээс гадуурх үйл ажиллагааны үеэр үргэлж амны хаалт зүүх ёстой. Та хичээлээс гадуурх үйл ажиллагааны үеэр хүмүүсээс аль болох зай барих шаардлагатай. Энэ нь бусад хүмүүсээс хамгийн багадаа 6 фийт буюу 2 метр (ойролцоогоор 2 дэлэм) хол зайтай байх ёстой гэсэн үг юм.

Сургуулиуд оролцогчдод эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ хийнэ. Оролцогчид:

- Хэрэв таны шинжилгээний хариу эерэг гарвал гэртээ өөрийгөө тусгаарлах ёстой.
- Хэрэв таны шинжилгээний хариу сөрөг гарч, тусгаарлагдаагүй эсвэл хөл хорионд ороогүй байгаа бөгөөд КОВИД-19 өвчний ямар нэг шинж тэмдэг илрээгүй бол хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцож болно.
- Шинжилгээнд хамрагдахгүй байхаар шийдсэн оролцогч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжгүй.



Мөн сургуулиуд "Дугуйланд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ" хөтөлбөрийн хүрээнд шинжилгээ өгөх хүсэлтэй боловч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдаагүй аливаа багш эсвэл ажилтанд шинжилгээ хийж болно.

## Шинжилгээний хариу нь эерэг гарсан аливаа хүний хавьтлыг тогтооно.

Шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнтэй хавьталд орсон сурагчид, багш нар эсвэл ажилчид хөл хорионы дэглэмийг мөрдөх хэрэгтэй (2-р хуудсанд бий).

- Хэрэв та болон шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн хоёулаа сургууль дээр байсан бөгөөд хавьталд орох үедээ хоёулаа амны хаалт зүүсэн байсан бол та хөл хорионд орох шаардлагагүй. Хэрэв хоёр хүн хоёулаа амны хаалт зүүсэн ч байсан шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн дор хаяж 10 хоног өөрийгөө тусгаарлах хэрэгтэй.
- Хэрэв та сургууль дээр хавьталд өртсөн бөгөөд та эсвэл шинжилгээний хариу нь эерэг гарсан хүн амны хаалт зүүгээгүй байсан бол та хөл хорионд орох шаардлагатай. Та шинжилгээ өгөхгүйгээр 10 дахь өдөр эсвэл шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд 7 дахь өдөр хөл хориог зогсоож болно. Танд 10 дахь өдрөөс өмнө сургуульдаа эргэж ирэхээсээ өмнө 2 дахь шинжилгээ өгөх шаардлага гарах нөхцөл байдал үүсэж магадгүй.

"Дугуйланд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ" сонголтын дагуу шинжилгээний хариу нь эерэг гарсан хүнийг тусгаарлаж эхлэх хугацааг янз бүрээр заасан заадаг. Хэрэв "Дугуйланд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ" хөтөлбөрийн хүрээнд таны шинжилгээний хариу эерэг гарвал шинж тэмдэг илэрч эхлэсэн өдөр бус харин шинжилгээ авсан өдрөөс эхлэн таныг тусгаарлана. Шинж тэмдэг илрээгүй ч гэсэн та өөрийгөө тусгаарлах ёстой. Таны шинжилгээ өгөх өдрөөс өмнө 2 хүртэл хоног тантай ойр хавьталд байсан аливаа хүн хөл хорионд орох хэрэгтэй. "Дугуйланд Явж Болох Зөвшөөрлийн Шинжилгээ" сонголтын хувьд үүнийг хамгийн сүүлийн хавьталд өртсөн өдөр гэж тооцно.